



АШИГТ МАЛТМАЛЫН
ГАЗРЫН ДАРГА
Г.АЛТАНСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.07 № 1/07 ЧАГ-САГ/2014/09/СГА-ТМЗ

Зориулалт бус зарцуулалтын тухай

Геологи мэдээллийн төвийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тесөл, хөтөлбөрийн зардлаас "Бодит бүртгэл аудит" ХХК-иар НББ-ийн бодлогын баримт бичгийг гүйцэтгүүлсний төлбөрт 6,000,000 төгрөгийг шилжүүлж, төслийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг болон төслийн гэрээнд заасан нөхцөлийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т: "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх....", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д ".....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна.

1. Тесөл, хөтөлбөрийн зардлыг холбогдох хууль тогтоомж, зохих заавар, журам, төслийн гэрээний нөхцөлийн дагуу зарцуулж байх
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэхийг ТЗҮХСҮТ-ийн дарга П.Болормаа, ахлах нягтлан бодогч С.ТүмэнҮндармаа наарт хариуцуулав.

АУДИТОР

П.ЧАНЦАЛДУЛАМ



070313